

АГААРЫН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮС МАКАОГИЙН
ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын Төв Засгийн газраас энэхүү Хэлэлцээрийг байгуулах эрхийг олгосон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг Захиргааны Онцгой Бүс Макаогийн Засгийн газар, (“Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүс”), Монгол Улсын Засгийн газар (цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэх)

Хоёр орны нутаг дэвсгэрийн хооронд болон тэдгээрийн чанадад агаарын тээврийн үйлчилгээ тогтоох зорилгоор Хэлэлцээр байгуулахыг эрмэлзэн,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Тодорхойлолт

Энэхүү Хэлэлцээрийн бичвэрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрийн зорилгод нийцүүлэн доорх нэр томъёог дараах утгаар ойлгоно.

(a) “Чикагогийн Конвенц” - Чикагод 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс гарын үсэг зурахад нээлттэй болсон Олон Улсын Иргэний нисэхийн Конвенц, үүний дотор: (i) Конвенцийн 94 (a) зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсон бөгөөд Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд дагаж мөрдөх боломжтой аливаа нэмэлт өөрчлөлтүүд; түүнчлэн (ii) энэ Конвенцийн 90 дүгээр зүйлийн дагуу батлагдсан аливаа Хавсралт болон Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд хэзээд хүчин төгөлдөр байх хавсралтанд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд;

(b) “нисэхийн удирдах байгууллага” - Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн хувьд Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Монгол Улсын хувьд Дэд бүтцийн яам, 7 дугаар зүйлийн зорилгод нийцүүлэх үүднээс Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, эсвэл аль ч тохиолдолд эдгээр байгууллагын одоогийн гүйцэтгэж буй эсвэл үүнтэй ижил үүрэг гүйцэтгэх эрх олгогдсон хувь хүн буюу байгууллага;

(c) “агаарын тээврийн томилогдсон компани” - энэхүү Хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн дагуу томилогдон, эрх авсан агаарын тээврийн компани;

(d) “газар нутаг”- Монгол Улсын хувьд Чикагогийн Конвенцийн 2 дугаар зүйлд заасан “нутаг дэвсгэр” гэсэн утгыг хэрэглэх ба Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн хувьд Макаогийн Пенинсула, болон Тайпа, Колоанийн арлуудыг багтаасан ойлголт;

(e) “агаарын тээврийн үйлчилгээ”, “олон улсын агаарын тээврийн үйлчилгээ”, “агаарын тээврийн компани”, “тээврийн бус зориулалттай буулт” гэсэн нэр томъёонууд нь Чикагогийн Конвенцийн 96 дугаар зүйлд тодорхойлсон утгыг тус тус илэрхийлнэ.

(f) “Хэлэлцээр” – энэхүү Хэлэлцээр, түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтүүд, түүний Хавсралт;

(g) “ашиглагчид ногдуулах хураамж” – эрх бүхий байгууллагаас агаарын тээврийн компанид ногдуулсан болон нисэх буудлын өмч, тоног төхөөрөмж эсвэл навигацийн тоног төхөөрөмж болон түүнд хамаарах үйлчилгээ, агаарын хөлөг, тэдгээрийн нисэх баг, зорчигч, ачаанд үзүүлсэн үйлчилгээнд ногдуулахыг зөвшөөрсөн төлбөр;

(h) “тогтоосон маршрут” – энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад заасан маршрут;

(i) “тохиролцсон үйлчилгээ” – тогтоосон маршрутаар үйлдэх агаарын тээврийн үйлчилгээ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Чикагогийн Конвенцийг мөрдөх

Энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд мөрддөг Чикагогийн Конвенцийн заалтуудтай нийцсэн байна.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Эрх олгох

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа олон улсын агаарын тээврийн үйлчилгээ явуулахад нь дараах эрхийг олгоно.

(a) газар нутаг дээгүүр нь буулт хийлгүй, дамжин нисч өнгөрөх;

(б) газар нутагт нь тээвэрлэлтийн бус зорилготой буулт хийх.

2. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа энэхүү Хэлэлцээрийн Хавсралтын зохих хэсэгт заасан маршрутаар олон улсын агаарын тээврийн үйлчилгээ явуулахад нь зориулж энэхүү Хэлэлцээрт заасан эрхийг олгоно. Эдгээр үйлчилгээ болон маршрутуудыг цаашид “тохиролцсон үйлчилгээ”, “тогтоосон маршрут” гэж тус тус нэрлэнэ.

Хэлэлцэн тохирогч Тал бүрийн томилсон агаарын тээврийн компани эсвэл компаниуд тогтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээ явуулахдаа энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхээс гадна зорчигч, ачаа түүнчлэн шууданг тусад нь эсвэл хамтад нь тээвэрлэхээр агаарын хөлгийн бүхээгт авах, буулгах зорилгоор Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дэх, энэхүү Хэлэлцээрийн Маршрутын Хуваарьт заасан маршрутын дагуух цэгүүдэд буулт хийх эрхтэй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэг нь Хэлэлцэн тохирогч нэг Талаас томилсон агаарын тээврийн компанид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дэх нэг цэгээс нөгөөд ашиг олох зорилгоор буюу хөлсөөр зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх эрх олгоогүй гэж ойлгоно.
4. Зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн үймээн самуун, түүний өрнөл, онцгой буюу хэвийн бус нөхцөл байдлын улмаас Хэлэлцэн тохирогч нэг Талын томилсон агаарын тээврийн компани ердийн маршрутаараа агаарын тээврийн үйлчилгээ явуулах боломжгүй болсон тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Тал түр хугацаагаар маршрутын зохих зохицуулалт хийх замаар дурьдагдсан үйлчилгээгээ үргэлжлүүлэх боломж бүрдүүлэхийг чармайна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Агаарын тээврийн компанийг томилох, зөвшөөрөл олгох

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа бичгээр мэдэгдэн тогтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээ явуулахаар агаарын тээврийн нэг эсвэл түүнээс дээш тооны компанийг томилж, уг томилолтоо цуцлах буюу өөрчилж болно.
2. Хэлэлцэн тохирогч нөгөө Тал ийм мэдэгдлийг авмагц энэ зүйлийн 3, 4 дахь хэсгийн заалтыг үндэслэн ийнхүү томилогдсон агаарын тээврийн компани эсвэл компаниудад үйл ажиллагаа явуулах зохих зөвшөөрлийг хойшлуулалгүй олгоно.
3. Хэлэлцэн тохирогч нэг Талын нисэхийн удирдах байгууллага Чикагогийн Конвенцийн заалтад нийцүүлэн тухайн удирдах байгууллагаас олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд ердийн болон зохистой байдлаар мөрддөг хууль тогтоомжиндоо тусгасан нөхцлийг биелүүлж чадна гэсэн нотолгоог Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилсон агаарын тээврийн компаниас шаардаж болно.
4. Хэлэлцэн тохирогч Тал бүр тухайн агаарын тээврийн компани хамтарсан байдлаар байгуулагдсан, уг компанийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын газар нутагт үйл ажиллагаа нь төвлөрдөг эсэх нь нотлогдоогүй гэж үзсэн аливаа тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохоос татгалзах, эсвэл энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхүүдийг эдлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тийм болзол тавих эрхтэй.
5. Ийнхүү томилогдон, эрх авсан агаарын тээврийн компани энэхүү Хэлэлцээрийн дагуу мөрдөгдөх нөхцлүүдийг хангасан тохиолдолд тохиролцсон үйлчилгээгээ эхэлж болно.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх

1. Хэлэлцэн тохирогч Тал бүрийн нисэхийн удирдах байгууллага, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилсон агаарын тээврийн компанид олгосон үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох эсвэл энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрх эдлэхийг нь түдгэлзүүлэх, эсвэл дор дурдсан тохиолдолд дурдсан эрх эдлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн болзол тавих эрхтэй. Үүнд:
 - (a) тухайн агаарын тээврийн компани хамтарсан байдлаар байгуулагдсан, уг компанийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын газар нутагт үйл ажиллагаа нь төвлөрдөг эсэх нь нотлогдоогүй гэж үзсэн тохиолдолд;
 - (b) тухайн агаарын тээврийн компани эрх олгосон Хэлэлцэн тохирогч нөгөө Тал ердийн болон зохистой байдлаар мөрддөг хууль тогтоомжийг зөрчсөн аливаа тохиолдолд; эсвэл
 - (c) агаарын тээврийн компани үйл ажиллагаа явуулахдаа энэхүү Хэлэлцээрт заасан нөхцлүүдийг ямарваа нэг өөр байдлаар зөрчвөл.
2. Хууль тогтоомжийг цаашид зөрчих явдлыг таслан зогсоох үүднээс нэн даруй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гараагүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүчингүй болгох, түдгэлзүүлэх, болзол тавих эрхийг зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагатай зөвлөлдсөний дараа хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

Багтаамжийн зохицуулалт

1. Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниуд тухайн Талуудын нутаг дэвсгэрийн хооронд тогтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээ явуулах шударга, тэгш боломжоор хангагдсан байна.
2. Хэлэлцэн тохирогч Тал бүрийн томилсон агаарын тээврийн компани эсвэл компаниуд тохиролцсон үйлчилгээ явуулахдаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилсон агаарын тээврийн компани буюу компаниудын тухайн маршрутаар эсвэл түүний хэсэгт хийж буй тээвэрлэлтэд хохирол учруулахгүйг эрмэлзэн энэ компани, компаниудын ашиг сонирхлыг харгалзан үзнэ.
3. Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниудын үзүүлж буй тохиролцсон үйлчилгээ нь тогтоосон маршрутын дагуух нийтийн тээврийн хэрэгцээтэй нягт уялдсан, агаарын тээврийн компаниудыг томилсон Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрээс буюу нутаг дэвсгэрт зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх өнөөгийн болон цаашдын хэрэгцээг даац ашиглалтын зохистой төвшинд нийцүүлсэн байх нь энэ үйлчилгээний эн тэргүүний зорилт байх бөгөөд багтаамж нь доорх зүйлээс хамаарах ерөнхий зарчмыг баримтална:

- (a) агаарын тээврийн компанийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын газар нутаг болон нутаг дэвсгэрээс хийх тээврийн шаардлага;
- (b) бүс нутгийг багтааж буй улсын агаарын тээврийн компанийн тээврийн бусад үйлчилгээг харгалзан үзсэний дараа тохирсон үйлчилгээ үзүүлж буй бүс нутгийн тээврийн хэрэгцээ; болон
- (c) агаарын тээврийн компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага.

ДОЛООДУГААР ЗҮЙЛ

Тариф

1. (a) “Тариф” гэж:
 - (i) зорчигч, тээш эсвэл ачаа /шууданг оруулалгүй/ тээвэрлэсний хөлс;
 - (ii) нэмэлт бараа, үйлчилгээ эсвэл эдгээр тээвэрт хийгдэх эсвэл хийгдэж болох, эсвэл тэдгээртэй холбогдон санамсаргүй гарсан эсвэл түүний үр дагавар болсон үйлдлээс гарах ашиг ;
 - (iii) эдгээр нэмэлт бараа, үйлчилгээнд ногдох үнэ эсвэл ашиг түүнчлэн аливаа дээрх бараа, үйлчилгээнд хэрэглэдэг эсвэл хэрэглэж болох үнэ болон ашгийн ногдлыг зохицуулдаг нөхцлүүд;
 - (iv) агаарын тээврийн компани агентдаа хуваарьт нислэгээр тээвэрлэх ачааны дагалдах хуудас бүрдүүлсэн, тасалбар борлуулсны төлөө төлөх шимтгэлийн хэмжээг хэлнэ.
- (b) Үнэ болон ханш даган өөрчлөгдөх ба Нислэг үйлдсэн тухайн улирал гараг эсвэл тухайн өдрийн цаг, аялалын чиглэл болон өөр бусад хүчин зүйлээс шалтгаалан үнэ шимтгэл ялгаатай байх нөхцөлд, зохих шатны удирдах байгууллага нөхцлүүдээс нь шалтгаалан тус тусад нь тогтоосон эсэхээс үл хамааран ялгаатай үнэ болон шимтгэл тус бүрийг тус тусдаа тариф гэж үзнэ.
2. Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниуд Талуудын газар нутгийн хооронд үйлдсэн тээвэрт мөрдөх тарифуудыг тохиролцсон үйлчилгээний ажиллагааны зардал, ашиглагчийн ашиг сонирхол, зохист ашиг болон зах зээлийн байдлыг харгалзан үндэслэлтэй төвшинд тогтооно.
3. Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн удирдах байгууллагууд дараах заалтуудад дурдсан үйлчилгээний тарифуудыг батлуулахаар танилцуулахаасаа өмнө агаарын тээврийн бусад компаниудтай зөвлөлдөхийг агаарын тээврийн өөрийн компаниудаас шаардахгүй.
4. Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд Хэлэлцэн тохирогч аль нэг Талын томилсон агаарын тээврийн компани Хэлэлцэн тохирогч нэг Талын газар нутаг дахь нэг цэгээс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын газар нутаг дахь цэгийн хооронд хийх тээвэртээ мөрдөх тарифуудыг дараах нөхцлийг баримтлан батлана.

Үүнд:

- a) Хэлэлцэн тохирогч Талуудын газар нутгийн хооронд хийх тээвэртээ мөрдөхөөр төлөвлөж буй аливаа тарифыг, уг тарифыг мөрдөхөөр товлосон өдрөөс 30 хоногийн өмнө (нисэхийн удирдах байгууллагууд тохиролцвол үүнээс богино хугацаанд) хоёр Талын нисэхийн удирдах байгууллагад агаарын тээврийн томилогдсон тухайн компани өөрөө эсвэл түүний нэрийн өмнөөс танилцуулна.
 - b) Ийнхүү танилцуулсан тарифыг нисэхийн удирдах байгууллагууд хэдийд ч баталж болно. Дараах хоёр дэд хэсгийг харгалзан Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд тарифын санал хүлээж авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор уг саналыг эс батлах тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол тухайн саналыг хүлээж авсан өдрөөс хойш 21 хоногийн дараа баталсанд тооцно.
 - c) Дээрх (b) дэд хэсэг Хэлэлцэн тохирогч аль ч Талын нисэхийн удирдах байгууллага өөрийн томилсон агаарын тээврийн аль нэг компанийн тарифын саналыг батлахаас дангаар татгалзах эрхийг хязгаарлаагүй болно. Нэг Талын ийм арга хэмжээг зөвхөн /тухайн тарифийг мөрдөх нь өрсөлдөөний эсрэг хандлагатай буюу агаарын тээврийн бусад компани болон компаниудад ноцтой хохирол үзүүлэхүйц/ нөхцөлд хэрэгжүүлнэ.
 - d) Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нисэхийн удирдах байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилсон агаарын тээврийн компанийн тарифын санал нь хэт өндөр тогтоосон эсвэл өрсөлдөөний эсрэг хандлагатай, агаарын тээврийн бусад компаниудад ноцтой хохирол үзүүлнэ хэмээн үзвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагатай зөвлөлдөх хүсэлтээ санал хүлээж авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор гаргаж болно. Ийм зөвлөлдөөнийг хүсэлт тавьсан өдрөөс хойш 21 хоногийн дотор хийх бөгөөд Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр тохироогүй бол энэ хугацаа дуусмагц тарифыг хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ.
 - e) Дээрх (a) – (d) дэд хэсгийг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд тэдний газар нутаг дахь цэгүүдийн хооронд ачаа тээвэрлэх тариф батлуулахыг шаардахгүй. Тийм тарифууд нь агаарын тээврийн тухайн компани хэрхэн шийдсэнээр мөрдөгднө.
 - f) Дээрх заалтуудын дагуу хүчин төгөлдөр мөрдөж буй тариф нь тодорхой маршрут эсвэл маршрутуудад агаарын тээврийн өөр компанид ноцтой хохирол учруулж байна хэмээн Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нисэхийн удирдах байгууллага үзвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагатай зөвлөлдөх хүсэлт тавьж болно. Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд өөрөөр тохироогүй бол ийм зөвлөлдөөнийг хүсэлт тавьсан өдрөөс хойш 21 хоногийн дотор хийнэ.
5. (a) Хэлэлцэн тохирогч нэг Талын томилсон агаарын тээврийн компанийн Хэлэлцэн тохирогч нөгөө Тал болон гуравдагч Талын газар нутгийн хооронд үйлдэх тээвэрт мөрдөх тарифыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын агаарын тээврийн удирдах байгууллага батална.

Танилцуулахаар оруулсан тариф болгон түвшин, нөхцөл, хүчинтэй хугацаагаараа нь агаарын тээврийн удирдах байгууллагын баталж, Хэлэлцэн тохирогч тухайн Талын томилсон агаарын тээврийн компани Хэлэлцэн тохирогч энэ Талын болон гуравдагч Талын газар нутгийн хооронд хийх тээвэртээ мөрдөж буй тарифтай ижил бол баталж болох бөгөөд эдгээр тарифыг аль нэг шалтгаанаар үргэлжлүүлэн мөрдөөгүй бол нисэхийн удирдах байгууллага олгосон баталгаагаа эгүүлэн татаж эсвэл зохицуулан мөрдөж буй тарифийн батлагдсан хувилбаруудад нийцүүлэн батлах нөхцлийг өөрчилж болно.

(b) Дээрх (a) дэд хэсгээс үл хамааран, Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн удирдах байгууллагууд Хэлэлцэн тохирогч аль нэг Талын томилсон агаарын тээврийн компани болон компаниуд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын болон гуравдагч Талын газар нутгийн хооронд ачаа тээвэрлэхдээ мөрдөх тарифыг батлахаар танилцуулахыг шаардахгүй.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

Гаалийн хураамж

1. Хэлэлцэн тохирогч аль ч Талын томилсон агаарын тээврийн компани олон Улсын агаарын тээврийн үйлчилгээндээ ашиглаж буй агаарын хөлөг, түүний байнгын тоноглол, шатахуун, тослох материал, сэлбэг хэрэгсэл, түүнчлэн хөдөлгүүр, агаарын хөлгийн нөөц (хүнс, ундааны зүйлс, тамхийг оролцуулан, гэхдээ хязгаарлалгүй) зэрэг агаарын хөлгийн бүхээг дэх зүйлсийг, хөлгийн бүхээгт үлдэх нөхцөлтэйгээр, нисэн ирэхэд нь үзүүлсэн үйлчилгээний үнэ дээр суурилагагүй гаалийн хураамж, онцгой татвар болон үүнтэй адилтгах төлбөр хураамжаас Хэлэлцэн тохирогч нөгөө Тал харилцан адил байх зарчмаар чөлөөлнө.
2. Агаарын хөлгийн байнгын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, шатах, тослох материалын хангамж, агаарын хөлгийн бүхээгийн нөөц, агаарын тээврийн томилогдсон компани өөрөө эсвэл түүний нэрийн өмнөөс Хэлэлцэн тохирогч нөгөө Талын газар нутагт оруулж ирсэн, агаарын тээврийн томилогдсон энэ компанийн олон улсын үйлчилгээндээ ашиглаж буй агаарын хөлгийн бүхээгт хэрэглэхээр хөлөгт авсан зорчигчийн тасалбарын нөөц, ачааны дагалдах хуудас, Хэлэлцэн тохирогч аль ч Талын томилсон агаарын тээврийн компани үнэгүй тараадаг ердийн танилцуулгаас ялгарах хэвлэмэл материалууд зэргийг Хэлэлцэн тохирогч нөгөө Тал харилцан адил байх зарчмаар, дээрх хангамжийн зүйлсийг Хэлэлцэн тохирогч тухайн Талын газар нутагт агаарын хөлгийн бүхээгт авсан бөгөөд нислэгийн маршрутын газар нутаг дээгүүр нь үйлдэх аль нэг хэсэгт ашиглах байсан ч нисэн ирэхэд нь үзүүлсэн үйлчилгээний үнэ дээр суурилагагүй гаалийн хураамж, онцгой татвар болон үүнтэй адилтгах төлбөр хураамжаас чөлөөлнө.
3. Энэ Зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан зүйлсийг зохих байгууллагуудын хараа хяналтын дор байлгахыг шаардаж болно.
4. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын томилсон агаарын тээврийн компанийн агаарын хөлгийн бүхээгт буй агаарын хөлгийн байнгын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл,

шатах, тослох материалын хангамжийн зүйлс, агаарын хөлгийн нөөцийг зөвхөн эдгээр материалуудыг эгүүлэн авч гарах эсвэл өөр байдлаар хэрэглэж дуусгах хүртэл гаалийн дүрэм журмын дагуу хяналтанд байлгахыг шаардах эрхтэй, Хэлэлцэн тохирогч тухайн Талын гаалийн байгууллагын зөвшөөрлийг үндэслэн Хэлэлцэн тохирогч энэ Талын газар нутагт буулгаж болно.

5. Хэлэлцэн тохирогч аль ч Талын томилсон агаарын тээврийн компани, дурдсан хураамжуудаас чөлөөлөгдөх эрхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Тал мөн адил эдлүүлдэг агаарын тээврийн компани болон компаниудтай Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэрт энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан зүйлүүдийг зээлдэх болон дамжуулах тохиролцоо хийсэн нөхцөлд энэ зүйлд заасан чөлөөлөгдөх эрхийг эдлэж болно.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Нисэхийн аюулгүй байдал

1. Хэлэлцэн тохирогч Талууд иргэний агаарын тээврийн хөлөг, түүний зорчигчид болон нисэх багийн аюулгүй байдал нь олон Улсын агаарын тээврийн үйлчилгээ эрхлэх эн тэргүүний нөхцөл гэж хүлээн зөвшөөрч иргэний нисэхийг хууль бус үйлдлээс хамгаалах талаар (тухайлбал, Чикагогийн Конвенци, 1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Токио хотноо гарын үсэг зурсан "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон бусад тодорхой үйлдлийн тухай Конвенц", 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Гааг хотноо гарын үсэг зурсан "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг таслан зогсоох тухай Конвенц", 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монреал хотноо гарын үсэг зурсан "Иргэний Нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдлийг таслан зогсоох тухай Конвенц"-ийн дагуу хүлээсэн үүрэг нь) харилцан хүлээсэн үүрэг нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэдгийг дахин нотолж байна.
2. Хэлэлцэн тохирогч Талууд иргэний агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, эдгээр хөлөг, түүний зорчигч, нисэх баг, нисэх буудал, агаарын навигацийн хэрэгслэлийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус бусад үйлдлүүд, иргэний нисэхийн аюулгүй байдалд учирсан аливаа бусад аюул заналаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай бүхий л туслалцааг харилцан үзүүлнэ.
3. Хэлэлцэн тохирогч Талууд өөр хоорондын харилцаандаа, нисэхийн аюулгүй байдлын Стандартууд болон Чикагогийн Конвенцид хавсралт болгон Иргэний нисэхийн олон Улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, заалтуудад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн Улсад бүртгэлтэй агаарын хөлөг ашиглагчид, газар нутаг дээр нь үйл ажиллагаагаа төвлөрүүлэн суурин ажилладаг, агаарын хөлөг болон нисэх буудал ашиглагчдаас агаарын тээврийн аюулгүй байдлын дээрх заалтуудыг мөрдөн ажиллахыг шаардана. Хэлэлцэн тохирогч Тал бүр нөгөө Талдаа мэдэгдэл өгөхөөр завдаж буй аливаа зөрүүний талаар урьдчилсан мэдээлэл өгнө.

4. Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн газар нутагт агаарын хөлгийг хамгаалах түүнчлэн зорчигчид, тэдний авч яваа зүйлс, нисэх багийг агаарын хөлөгт оруулахдаа тусгай дэлгэцээр харж шалгах, тээвэрлэгдэж буй эд зүйлс, ачаа (гар тээшийг оруулан), бүхээгийн нөөцийг ачихаас өмнө болон ачих үеэр үзлэг шалгалт хийхтэй холбогдсон үр дүнтэй арга хэмжээ авах бөгөөд эдгээр арга хэмжээ нь өсөн нэмэгдэж буй аюул заналаас хамгаалах шаардлагад дүйцсэн байна. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын газар нутагт орох, гарах болон түүний хилийн дотор байх үед энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нисэхийн аюулгүй байдлын заалтуудыг мөрдөхийг агаарын тээврийн компаниудаас шаардаж байхаар Хэлэлцэн тохирогч Талууд тохиров. Хэлэлцэн тохирогч Тал бүр тодорхой аюулын эсрэг аюулгүй байдлын зохистой тусгай арга хэмжээ авах талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас тавьсан аливаа хүсэлтийг нааштай хүлээн авна.
5. Иргэний агаарын тээврийн хөлгийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аливаа хууль бус үйлдэл, эсвэл аюул занал, эдгээр хөлөг, түүний зорчигчид, нисэх баг, түүнчлэн нисэх буудал, агаарын навигацийн хэрэгслэлийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аливаа бусад хууль бус үйлдэл гарсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд дээрх үйлдэл буюу аюул заналыг шуурхай, осолгүй таслан зогсооход чиглэсэн холбоо барих болон бусад зохих арга хэмжээг авч харилцан туслалцаж ажиллана.

АРАВДУГААР ЗҮЙЛ

Бүртгэл мэдээллээр хангах

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нисэхийн удирдах байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагын хүсэлтээр энэ зүйлд эхлэн дурдсан Хэлэлцэн тохирогч Талын томилсон агаарын тээврийн компаний тохиролцсон үйлчилгээний багтаамжинд дүн шинжилгээ хийхэд зохих ёсоор шаардагдах тоо бүртгэлийн тогтмол болон бусад мэдээллийг өгнө. Эдгээр мэдээлэл нь агаарын тээврийн томилогдсон компани тохиролцсон үйлчилгээндээ гүйцэтгэсэн тээвэрлэлтийн тоо хэмжээ, эдгээр тээвэрлэлтийн эхлэл, төгсгөлийн цэгүүдийг тодорхойлоход шаардагдах бүх мэдээг агуулна.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Орлого шилжүүлэх

Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн агаарын тээврийн томилогдсон компани үйл ажиллагааны зарлагаас давсан орлогоо Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүс рүү хөрвүүлэх, гуйвуулах эрхтэй. Монгол Улсын агаарын тээврийн томилогдсон компани үйл ажиллагааны зарлагаас давсан орлогоо өөрийн Улс руу хөрвүүлэх, гуйвуулах эрхтэй. Орлогыг хөрвүүлэх, гуйвуулах ажиллагааг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж буй ханшаар, банкнаас орлого хөрвүүлэх, гуйвуулахад ногдуулдаг хураамжаас өөр төлбөргүйгээр аливаа хязгаарлалтгүй хийхийг зөвшөөрнө.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Агаарын тээврийн компанийг төлөөлөх, үйлчилгээ худалдах

1. Хэлэлцэн тохирогч нэг Талаас томилогдсон агаарын тээврийн компани Хэлэлцэн тохирогч нөгөө Талын газар нутагт нь зорчих, оршин суух, ажил эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу агаарын тээврийн үйлчилгээгээ явуулахад шаардагдах удирдлагын, техникийн, үйл ажиллагаа эрхлэх болон бусад мэргэжлийн ажилтнуудаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын газар нутаг дэвсгэрт оруулах, суурин ажиллуулж болно.
2. Хэлэлцэн тохирогч Тал бүрийн томилсон агаарын тээврийн компани, компаниуд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын газар нутагт өөрөө шууд эсвэл агаарын тээврийн компанийн томилсон агентуудаар дамжуулан агаарын тээвэр худалдаж болно. Хэлэлцэн тохирогч Тал бүрийн томилсон агаарын тээврийн компани, компаниуд ийм тээврийг худалдах, аливаа хүн орон нутгийн эсвэл чөлөөтэй хөрвөдөг бусад валютаар түүнийг чөлөөтэй худалдан авах боломжтой байна

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Ашиглагчид ногдуулах хураамж

1. Хэлэлцэн тохирогч аль ч Тал, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилсон агаарын тээврийн компанид, ашиглалтын хураамжийг, олон Улсын агаарын тээврийн ижил төрлийн үйлчилгээ эрхэлж буй өөрийн компаниудад ногдуулдгаас илүүгээр ногдуулахгүй буюу ногдуулахыг зөвшөөрөхгүй.
2. Хэлэлцэн тохирогч Тал бүр хураамж ногдуулах эрх бүхий дотоодын байгууллагууд, эдгээр байгууллагаар үйлчлүүлж, тоног төхөөрөмжийг нь ашигладаг агаарын тээврийн томилогдсон компаниудын хооронд ашиглалтын хураамжийн асуудлаар, боломжтой бол компанийн төлөөлөгчийн газартай зөвлөлдөөн хийж байхыг дэмжинэ. Ашиглагчид саналаа илэрхийлэх боломж олгох үүднээс ашиглалтын хураамжид оруулах аливаа өөрчлөлтийн талаар уг өөрчлөлтийг хийхээс өмнө зохих мэдэгдэл өгнө. Хэлэлцэн тохирогч Тал бүр хураамж ногдуулах эрх бүхий байгууллага, ашиглагчдын хооронд хураамжийн талаар зохих мэдээлэл солилцохыг цаашид ч дэмжинэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Зөвлөлдөөн

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх, тайлбарлах, хэрэглэх, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар зөвлөлдөх хүсэлтээ хэзээ ч гаргаж болно. Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр тохироогүй бол нисэхийн удирдах байгууллагуудын төвшинд хийж болох ийм зөвлөлдөөн Хэлэлцэн тохирогч нөгөө Тал зөвлөлдөх хүсэлтийг бичгээр хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор эхэлнэ.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

Маргааныг шийдвэрлэх

1. Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах буюу хэрэглэхтэй холбогдсон аливаа маргаан үүсвэл Талууд эн тэргүүнд хэлэлцээний замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
2. Хэлэлцэн тохирогч Талууд маргааныг хэлэлцээний замаар шийдвэрлэж чадаагүй бол маргааныг шийдвэрлүүлэхээр тохиролцвол хувь хүн буюу байгууллагад эсвэл Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр гурван арбитрчаас бүрдэх арбитра хандаж болох ба арбитраг дараах байдлаар байгуулагдсан байна.
 - a) маргааныг арбитраын шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлт тавьснаас хойш 30 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч Тал тус бүр нэг арбитраг томилно. Хоёрдахь арбитраг томилсноос хойш жар хоногийн дотор, хоёр арбитрагийн тохиролцсоноор, маргаанд үл хамаарах Улсын харъяат, арбитрайн шүүхийн Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэх гуравдахь арбитраг томилно.
 - b) дээр тогтоосон хугацаанд аливаа томилолт хийгдээгүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Иргэний нисэхийн олон Улсын байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгчид хандан шаардлагатай томилолтыг 30 хоногийн дотор хийхийг хүсч болно. Зөвлөлийн Ерөнхийлөгч уг маргаанд хамаарах улсын харъяат бол ийм шалтгаанаар эрх нь хязгаарлагдаагүй, Иргэний нисэхийн олон улсын байгууллагын Зөвлөлийн дараагийн шатны Гишүүнд томилгоо хийлгэх хүсэлтээ тавина.
3. Хэлэлцэн тохирогч Талууд энэ зүйлд зааснаас өөрөөр тохироогүй бол арбитра өөрийн хэргийн харьяалалын хязгаар, дэгээ тогтооно. Арбитраын шийдвэрээр эсвэл Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр Арбитраг бүрэн байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор арбитраар хэлэлцэх тухайн асуудал, баримтлах тусгай дэгийг тогтоох хурлыг хийнэ.
4. Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр тохироогүй, арбитра өөрөөр тогтоогоогүй бол арбитраг бүрэн байгуулагдсанаас хойш 45 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч Тал бүр меморандум бэлтгэж ирүүлнэ. Хэлэлцэн тохирогч Тал бүр меморандум ирүүлснээс хойш 60 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас хариу өгч болно. Арбитра хариу ирүүлэх эсвэл түүний хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр эсвэл өөрийн үзэмжээр хэрэг сонсох хуралдаан явуулна.
5. Арбитра хэрэв хоёр тал арбитраг хариу өгснөөс хойш 30 хоногт хэргийг сонсоогүй бол, хэрэг сонсож дууссанаас хойш 30 хоногийн дотор шийдвэрээ бичгээр гаргаж өгөхийг эрмэлзэнэ. Шийдвэрийг олонхийн саналаар гаргана.
6. Хэлэлцэн тохирогч Талууд шүүхийн шийдвэр хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор түүнийг тодруулах хүсэлт тавьж болох бөгөөд хүсэлт хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор тийм тодруулгыг хийж өгнө.
7. Хэлэлцэн тохирогч Талууд шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

8. Хэлэлцэн тохирогч Талууд өөрсдийн томилсон арбитрчын зардлыг хариуцна. Арбитрын бусад зардал болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн (b)-д дурдсан ажиллагааг хэрэгжүүлэхэд болон Иргэний нисэхийн олон улсын байгууллагын Ерөнхийлөгч, эсвэл Гишүүнтэй холбогдон гарсан зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд тэнцүү хувааж төлнө.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

Нэмэлт өөрчлөлт оруулах

1. Хэлэлцэн тохирогч Талууд тохиролцож энэхүү Хэлэлцээрт оруулсан нэмэлт өөрчлөлтүүд зохих шугамаар баримт бичиг солилцон баталснаар хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд шууд тохиролцож болно. Эдгээр өөрчлөлтүүдийг дээр дурдсан удирдах байгууллагууд тохиролцсон өдрөөс эхлэн түр хугацаагаар мөрдөгдөх бөгөөд зохих шугамаар баримт бичиг солилцон баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ

Түрээсийн онгоц ашиглах

Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниуд тохиролцсон үйлчилгээндээ түрээслэсэн агаарын хөлөг болон нисэх багийг ашиглаж болох бөгөөд түрээсийн эдгээр тохиролцоог Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дотоодын дүрэм, журмын дагуу тухайн Талын иргэний нисэхийн удирдах байгууллага батална.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Олон талт конвенциуд

Хэлэлцэн тохирогч Талуудад хэрэглэгдэх агаарын тээврийн олон талт ерөнхий конвенц хүчин төгөлдөр болох тохиолдолд тийм конвенцийн заалтуудыг баримтална. Олон талт конвенцийн заалтын дагуу энэхүү Хэлэлцээрийг цуцлах, орлуулах, нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл хавсралт хийх асуудлыг тодорхойлох аливаа уулзалтыг энэхүү Хэлэлцээрийн 16 дугаар зүйлийн хийнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ**Хэлэлцээрийг цуцлах**

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухай шийдвэрээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа бичгээр хэдийд ч мэдэгдэж болно. Ийм мэдэгдлийг Иргэний нисэхийн олон Улсын байгууллагад нэгэн зэрэг өгнө. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч нөгөө Тал мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш бүтэн 1 жил болохын өмнөх өдрийн шөнө дундад /мэдэгдэл хүлээн авсан газрын цагаар/, хэрэв энэ хугацаа дуусгавар болохоос өмнө уг мэдэгдлийг хэлэлцэн тохирч эгүүлэн аваагүй бол цуцлагдана. Хэлэлцэн тохирогч нөгөө Тал мэдэгдэл хүлээн авсан тухайгаа нотлоогүй бол Иргэний нисэхийн олон Улсын байгууллага уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дараа мэдэгдлийг хүлээн авсанд тооцно.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ**Иргэний нисэхийн олон Улсын байгууллагад бүртгүүлэх**

Энэхүү Хэлэлцээр болон түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг Иргэний нисэхийн олон Улсын байгууллагад бүртгүүлнэ.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ**Хүчин төгөлдөр болох**

Хэлэлцэн тохирогч Талууд хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох шаардлагыг биелүүлсэн тухайгаа бичгээр харилцан мэдэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

Дор гарын үсэг зурагсад энд өгүүлсэн зүйлийг нотолж, өөрсдийн Засгийн газраас олгосон эрхийн дагуу энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг 2006 оны 6 -р сарын 27-ны өдөр Хятад, Португал, Монгол, Англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд бүх бичвэрүүд адил хүчинтэй байна.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН
МАКАОГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ
ОНЦГОЙ БҮСИЙН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



Ао Ман Лонг
Тээвэр, дэд бүтцийн асуудал эрхэлсэн
Нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



Ц.Цэнгэл
Зам, тээвэр, аялал
жуулчлалын сайд

ХАВСРАЛТ**МАРШРУТЫН ХУВААРЬ****1 дүгээр хэсэг**

Монгол Улсын томилсон агаарын тээврийн компани, компаниуд агаарын тээврийн үйлчилгээ явуулах маршрутууд:

Монгол Улс дахь цэгүүд	Завсрын цэгүүд	Макаогийн ЗЗОБ дахь цэгүүд	Цааш орших цэгүүд
Улаанбаатар	Хожим тодорхойлно	Макао, ЗЗОБ	Хожим тодорхойлно

ТАЙЛБАР:

1. Монгол Улсаас эхэлж, төгсч байгаа аль ч нислэгтээ завсрын цэгүүдийг алгасч болно.
2. Эх газрын Хятад, Тайвань, Хонг Конг дахь аль ч цэгүүдийг завсрын болон цааш орших цэгүүд гэж үзэхгүй.

2 дугаар хэсэг

Макаогийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн томилсон агаарын тээврийн компанийн агаарын тээврийн үйлчилгээ явуулах маршрутууд:

Макаогийн ЗЗОБ цэгүүд	Завсрын цэгүүд	Монгол Улс дахь цэгүүд	Цааш орших цахь цэгүүд
Макао. ЗЗОБ	Хожим тодорхойлно	Улаанбаатар	Хожим тодорхойлно

ТАЙЛБАР:

1. Макаогийн ЗЗОБ-ээс эхэлж, төгсч байгаа аль ч нислэгтээ завсрын цэгүүдийг алгасч болно.
2. Эх газрын Хятад, Тайвань, Хонг Конг дахь аль ч цэгүүдийг завсрын болон цааш орших цэгүүд гэж үзэхгүй.